



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/141

Улаанбаатар хот

Тэмцээн зохион явуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Биеийн тамир, спортын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 14.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Онцгой байдлын газрын төв байрны бүтцийн нэгжийн алба хаагчдын дунд 2019 оны аварга шалгаруулах 3 төрөлт (гар бөмбөг, сагсан бөмбөг, ширээний теннис) тэмцээнийг 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулсугай.

2. Тэмцээний удирдамжийг нэгдүгээр, тэмцээнд шаардагдах зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээн зохион явуулахад шаардагдах зардал 1,827,000 (нэг сая найман зуун хорин долоон мянга) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын хэлтэс (дэд хурандаа Б.Баттулга)-т даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА



Ж.ЧҮЛТЭМСҮРЭН

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн
А/Н дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН 2019 ОНЫ
АВАРГА ШАЛГАРУУЛАХ СПОРТЫН 3 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ
(ГАР БӨМБӨГ, САГСАН БӨМБӨГ, ШИРЭЭНИЙ ТЕННИС)**

Нэг: Зорилго

Нийслэлийн Онцгой байдлын газрын алба хаагчдыг биеийн тамир, спортын нэгдсэн арга хэмжээнд оролцуулах, бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл мэндийг бэхжүүлэх, чөлөөт цагаа спортоор хичээллэж зөв боловсон өнгөрүүлэхэд оршино.

Хоёр: Тэмцээн явуулах журам, оролцох багууд.

Нийслэлийн Онцгой байдлын газрын хэлтэс, тасаг нийт 6 баг, НИГХСАЗТ-ийн 1 баг, Аврах анги-105-ын төв штабын 1 багын тамирчид оролцоно.

Тэмцээнд оролцох багууд өөр өөрийн ижил тоглолтын хувцастай байна.

Гурав. Тэмцээний төрөл

1. Гар бөмбөг:

Гар бөмбөгийн тэмцээнийг газар, хэлтсээс эрэгтэй эмэгтэй холимог баг оролцуулна.

Нэг багт 6 тамирчинтай байна. Тоглолтод 2 эмэгтэй тамирчин заавал тоглуулах ба эмэгтэй тамирчин тоглуулаагүй тохиолдолд тухайн багыг тэмцээнээс шууд хасна.

2. Сагсан бөмбөг:

Сагсан бөмбөгийн тэмцээнийг газар, хэлтсээс эрэгтэй эмэгтэй холимог баг оролцуулна.

Нэг багт 6 тамирчинтай байна. Тоглолтод 2 эмэгтэй тамирчин заавал тоглуулах ба эмэгтэй тамирчин тоглуулаагүй тохиолдолд тухайн багыг тэмцээнээс шууд хасна.

3. Ширээний теннис:

Багын бүрэлдэхүүн 2 эрэгтэй, 2 эмэгтэй хүнээс бүрдэх 2 тоглолтоор ялагчийг тодруулах ба тэнцсэн тохиолдолд гурав дахь тоглолтыг явуулна.

Дөрөв: Тэмцээнийг дүгнэх, зохион байгуулах хугацаа

Тэмцээнийг “Аврагч” спорт хорооны шүүгчид шүүн явуулна. Техникийн зөвлөгөөнийг 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 14.00 цагт НОБГ-ын Соёлын төвд зохион явуулна. Багууд оролцох тамирчдынхаа мэдүүлгийг техникийн зөвлөгөөн дээр өгнө. Мэдүүлэгт тухайн тамирчны спортын төрөл, цол зэргийг заавал тусгана.

Тэмцээн “Аврагч” Биеийн тамир спорт хорооны зааланд 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 08.30 цагаас эхэлнэ.

Тэмцээнтэй холбоотой маргаан гарвал тухайн багийн ахлагч шүүгчид хандаж шийдвэрлүүлнэ.

Дөрөв: Шагнал урамшуулал

I байр: Медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал,

II байр: Медаль, өргөмжлөл,

III байр: Медаль, өргөмжлөл спортын төрлүүдийн нийлбэр дүнгээр тэргүүн байр эзэлсэн багт цом хадгалуулах ба төрөл тус бүрт шилдэг тамирчин шалгаруулна.

---oOo---

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн
2019/12/20 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ТЭМЦЭЭНД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Зарцуулагдах материал	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Гар бөмбөг 1-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг	-	200,000
2	Гар бөмбөг 2-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг	-	150,000
3	Гар бөмбөг 3-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг	-	100,000
4	Сагсан бөмбөг 1-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг	-	200,000
5	Сагсан бөмбөг 2-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг	-	150,000
6	Сагсан бөмбөг 3-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг	-	100,000
7	Ширээний теннис 1-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг	-	80,000
8	Ширээний теннис 2-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг	-	50,000
9	Ширээний теннис 3-р байр, мөнгөн шагнал	1	Ширхэг	-	30,000
10	Медаль	48	Ширхэг	7950	381,600
11	Өргөмжлөлийн жааз	9	Ширхэг	5000	45,000
12	Шилдэг тамирчин	3	Ширхэг	30000	90,000
13	Цом	4	Ширхэг	40100	160,400
14	Шүүгч	3	хүн	30000	90,000
Бүгд					1,827,000